

Монголын Хөлбөмбөгийн Холбоо ТББ-ын ДҮРЭМ

*2018 оны 03 дугаар сарын 23-ны
өдрийн МХБХ-ны VII Их хурлын №06
тоот тогтоолоор шинэчлэн батлав.*

ДАРААХ НЭР ТОМЬЁОГ ДОР ДУРДСАНААР ОЙЛГОНО:

МХБХ: “Монголын Хөлбөмбөгийн Холбоо”, /Олон улсын хөлбөмбөгийн холбооноос гишүүнээр хүлээн зөвшөөрөгдсөн хөлбөмбөгийн холбоо/

ОУХБХ: “Олон Улсын Хөлбөмбөгийн Холбоо”;

АХБХ: “Азийн Хөлбөмбөгийн Холбоо”;

Лиг: Холбоонд захирагдах байгууллага;

Орон нутгийн хөлбөмбөгийн холбоо: Холбоонд захирагдах байгууллага;

Тивийн холбоо: ОУХБХ-ноос хүлээн зөвшөөрсөн, нэг ижил тивд хамаарах (газар зүйн ижил бүсэд оршдог) Холбоодын нэгдэл;

Клуб: ОУХБХ-ны гишүүн Холбооны гишүүн эсвэл тэмцээнд нэгээс доошгүй баг нь оролцдог Холбооноос хүлээн зөвшөөрсөн Лигийн гишүүн;

Албаны хүмүүс: ОУХБХ, Тивийн холбоо, ОУХБХолбооны гишүүн холбоо, Лиг, Клуб ба ОУХБХолбооны дүрмийг сахин биелүүлдэг аливаа этгээдийн техник, спортын анагаах ухаан ба захиргааны асуудал хариуцсан Удирдах зөвлөл, хорооны гишүүн, шүүгч ба туслах шүүгч, дасгалжуулагч, сургагч зэрэг тоглогчоос бусад гишүүдийг хэлнэ.

Тоглогч: Холбоонд бүртгэлтэй хөлбөмбөгийн тоглогч;

Их хурал: Холбооны эрх барих дээд байгууллага;

Зөвлөл: Холбооны стратеги ба бодлого тодорхойлох байгууллага;

Гишүүн: Их хурлаас Холбооны гишүүн хэмээн хүлээн зөвшөөрсөн хувь хүн болон хуулийн этгээд;

Холбооны тэмцээн уралдаанууд: ОУХБХ-ноос хяналт тавьж Тоглолтын Дүрэмд заасны дагуу зохион байгуулагдах тэмцээн;

ОУХБХ-ны зөвлөл: Олон Улсын Хөлбөмбөгийн Холбооны Зөвлөл;

Шүүх: Нийтийн болон хувийн эрх зүйн маргааныг шийддэг шүүх;

Үндэсний Арбитр: Монгол газар нутаг дээр маргааныг шүүхийн бус аргаар шийдвэрлэх эрх бүхий, МХБХ-нд хүлээн зөвшөөрөгдсөн хуулийн дагуу байгуулагдсан бие даасан байгууллага;

Спортын Арбитрын Шүүх (САШ): Швейцарь Улсын Лозанна хотод байрладаг Спортын Арбитрын Шүүх;

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөлбөмбөгийн зөвлөл: Монголын Тусгай Олимпын Хорооны төлөөллөөс бүрдсэн зөвлөлийг хэлнэ.

Тэмдэглэл: Дүрэмд заасан хувь хүн гэсэн нэр томьёо нь бүх төрлийн хүйсийн этгээдийг илэрхийлнэ. Нэг тоон дээр бичигдсэн аливаа нэр томьёо нь олон тоог, мөн олон тоо нь нэг тоог илэрхийлнэ.

I. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1-р зүйл. Нэр, төв байр болон хуулийн этгээдийн хэлбэр

1. Монголын Хөлбөмбөгийн Холбоо нь (цаашид “**Холбоо**” гэх) Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу 1959 оны 10 сарын 30-ны өдөр үүсгэн байгуулагдаж, Хууль зүйн яаманд 10009656 дугаартайгаар бүртгэгдсэн, Холбооны шинж чанартай олон нийтийн Төрийн Бус Байгууллага мөн. Тус төрийн бус байгууллага нь хугацаагүйгээр үйл ажиллагаа явуулна.
 2. Холбооны төв байр нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороонд байрлана.
 3. Холбоо нь Олон Улсын Хөлбөмбөгийн Холбоо болон Азийн Хөлбөмбөгийн Холбооны гишүүн мөн болно.
 4. Холбооны туг нь Хавсралт №1-т заасны дагуу байна.
 5. Холбооны бэлгэ тэмдэг нь Хавсралт №2-т заасны дагуу байна.
 6. Туг, бэлгэ тэмдэг нь Олон улсын ба Монгол Улсын Оюуны Өмчийн эрх бүхий байгууллагад хууль ёсны бүртгэлтэй байна.
-

2-р зүйл. Зорилго

1. Холбоо нь дараах зорилготой байна. Үүнд:
 - 1.1. Хөлбөмбөгийн спортыг тогтвортой хөгжүүлэх мөн хүүхэд залуучуудын болон хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар хөлбөмбөгийн спортын эв нэгдэл, боловсрол, соёл болон хүмүүнлэгийн ач холбогдлыг Монгол Улс даяар сурталчлан таниулж мөрдөх;
 - 1.2. Улсын чанартай бүх төрлийн хөлбөмбөгийн тэмцээнийг зохион явуулах;
 - 1.3. Холбогдох журам, зааврыг боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтийг хангах;
 - 1.4. Холбооны гишүүдийн ашиг сонирхлыг хамгаалах;
 - 1.5. ОУХБХ, АХБХ-ны Дүрэм, Журам, шийдвэр болон Тоглолтын дүрэм зөрчигдөхөөс сэргийлж өөрөө болон өөрийн гишүүдээр эдгээр дүрэм, журам, шийдвэрийг дагаж мөрдүүлэх;
 - 1.6. Холбооны гишүүд, албаны хүмүүс, тоглогчид, уралдаан тэмцээн ба тоглолтуудын нэр хүндэд сөрөг нөлөө үзүүлэх эсвэл Холбооны зохион байгуулдаг тэмцээн уралдааныг гутаан доромжлоход хүргэх аливаа авилга, сэргээш, тоглолтыг урьдчилан үгсэн тохирох зэрэг зүй бус үйлдлүүдээс урьдчилан сэргийлэх үүднээс эв нэгдэл, ёс зүй, шударга тоглолтыг хөхүүлэн дэмжих;
 - 1.7. Монгол Улсын нутаг дэвсгэрт зохион байгуулах хөлбөмбөгийн бүх төрлийн нөхөрсөг тоглолтод хяналт тавьж, удирдлагаар хангах;
 - 1.8. Улсын аваргын төвшний тэмцээнүүд болон Монгол Улсын нутаг дэвсгэрт зохион байгуулагдах олон улсын чанартай тоглолтуудад ОУХБХ, АХБХ-ны дүрэм болон холбогдох журмын дагуу хэрэгжилтийг хангаж, удирдлагаар хангах;
 - 1.9. Холбооны тэмцээн уралдаантай холбоотой бүхий л спортын олон улсын харилцааг зохицуулах;
-

- 1.10. Олон улсын болон бусад төвшний тэмцээнүүдийг эх орондоо хүлээн авч зохион байгуулах;

3-р зүйл. Төвийг сахих, үл ялгаварлан гадуурхах

1. Холбоо нь улс төр, шашны асуудлаар төвийг сахисан байр суурь баримтална.
2. Арьс өнгө, үндэс, угсаа болон нийгмийн гарал, хүйсийн ялгаа, хэл, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодол болон бусад үзэл бодол, хөгжлийн бэрхшээлтэй эсэх, чинээлэг байдал, хүйсийн чиг хандлага зэрэг шалтгаанаар улс орон, хувь хүн эсвэл бүлэг хүмүүсийг ялгаварлан гадуурхах аливаа явдлыг хатуу хориглож ийм явдал гаргавал гишүүнээс түр болон бүрмөсөн түдгэлзүүлэх арга хэмжээ авна.

4-р зүйл. Нөхөрсөг харилцааг дэмжих

1. Холбоо нь хүмүүнлэгийн зорилгоор өөрийн гишүүд, клубүүд, албаны хүмүүс ба тоглогчдын хооронд болон нийгэмд нөхөрсөг харилцааг хөгжүүлнэ.
2. Холбооны уралдаан тэмцээнд оролцож буй аливаа хувь хүн болон байгууллага нь холбооны Дүрэм болон холбогдох журам, заавар, түүнчлэн шударга тоглолт ба эв нэгдлийн зарчмыг сахин дагаж мөрдөх үүрэгтэй.
3. Холбоо нь өөрийн гишүүн, клубүүд, албаны хүмүүс, тоглогчдын хооронд үүсч болзошгүй дотоодын чанартай аливаа маргааныг таслан шийдвэрлэх шаардлагатай бүтэцтэй болно.

5-р зүйл. Тоглогч

1. ОУХБХ-ны Тоглогчийн Шилжилт хөдөлгөөний журамд нийцүүлэн Зөвлөлөөс Тоглогчийн эрх зүйн байдал ба шилжилт хөдөлгөөний журмыг батална.
2. Тоглогчдыг Холбооны журмын дагуу бүртгэнэ.

6-р зүйл. Тоглолтын дүрэм

1. Холбоо, түүний гишүүд нь Олон Улсын Хөлбөмбөгийн Холбооны Зөвлөлөөс баталсан “Тоглолтын дүрэм”-ийн дагуу холбооны тэмцээн уралдаанд оролцоно. “Тоглолтын дүрэм”-ийг гагцхүү Олон Улсын Хөлбөмбөгийн Холбооны Зөвлөлөөс (IFAB) тогтоох ба өөрчилнө.
2. Холбоо болон түүний гишүүд футзал, элсний хөлбөмбөгийг Футзалын “Тоглолтын Дүрэм” болон Элсний хөлбөмбөгийн “Тоглолтын Дүрэм”-ийн дагуу тоглоно. Футзалын болон Элсний хөлбөмбөгийн Тоглолтын Дүрмүүдийг зөвхөн ОУХБХ-ноос тогтоох ба өөрчилнө.

7-р зүйл. Байгууллага, албаны хүмүүсийн ёс зүй

1. Холбооны байгууллагын гишүүд болон албаны хүмүүс нь үйл ажиллагаандаа ОУХБХ, АХБХ болон Холбооны Дүрэм, журам, шийдвэр, зааварчилга болон Ёс зүйн дүрмийг дагаж мөрдөнө.

8-р зүйл. Албан ёсны хэл

1. Холбооны албан ёсны хэл нь Монгол хэл байна. Холбооны дүрмийг Монгол, Англи хэлээр үйлдэнэ. Хэрэв дүрэмд зөрүүтэй байдал үүссэн тохиолдолд Англи хэл дээрх хувилбарыг баримтална.

II. ГИШҮҮНЧЛЭЛ

9-р зүйл. Гишүүнээр элсүүлэх, гишүүнчлэлийг түдгэлзүүлэх, гишүүнээс чөлөөлөх

1. Гишүүнээр элсүүлэх, гишүүнчлэлийг түдгэлзүүлэх ба гишүүнээс чөлөөлөх асуудлыг Холбооны Их хурал шийдвэрлэнэ.
2. Тус дүрмийн дагуу Холбооноос тавьж буй шаардлагыг хангасан тохиолдолд гишүүнээр элсүүлж болно.
3. Гишүүнээс татгалзсан эсвэл чөлөөлөгдсөн тохиолдолд гишүүнчлэлийг дуусгавар болгоно. Гишүүнчлэлээ алдсанаар уг гишүүний Холбоонд хамаарах бүхий л эрх дуусгавар болох боловч энэ нь гишүүн байхдаа Холбоо болон Холбооны бусад гишүүдийн өмнө хүлээсэн санхүүгийн үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

10-р зүйл. Гишүүнээр элсүүлэх

1. Холбоо нь дараах гишүүдээс бүрдэнэ. Үүнд:
 - 1.1. Орон нутгийн хөлбөмбөгийн холбоо 21;
 - 1.2. Клубүүд 24 (Дээд, 1-р лиг болон хүүхдийн клубүүд);
 - 1.3. Шүүгчдийн зөвлөл;
 - 1.4. Дасгалжуулагчдын зөвлөл;
 - 1.5. Эмэгтэй хөлбөмбөгийн зөвлөл;
 - 1.6. Ахмадын зөвлөл;
 - 1.7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөлбөмбөгийн зөвлөл;
2. Холбооны гишүүнээр элсэх хүсэлтэй хуулийн этгээд Холбооны Ерөнхий нарийн бичгийн даргын газарт бичгээр хүсэлтээ гаргаж өгнө.
3. Өргөдлийг дараах зайлшгүй байх дагалдах бичиг баримтын хамт өгнө. Үүнд:
 - 3.1. Хүсэлт гаргагчийн хуулийн хүчин төгөлдөр дүрмийн хуулбар;
 - 3.2. ОУХБХ, АХБХ болон Холбооны Дүрэм, журам, шийдвэрийг өөрөө болон гишүүд, клубүүд, албаны хүмүүс, тоглогчид нь дагаж биелүүлэх амлалт;
 - 3.3. Хүчин төгөлдөр үйлчилж буй Тоглолтын Дүрмийг сахиж биелүүлэх тухай амлалт;

- 3.4. ОУХБХ, АХБХ болон Холбооны дүрэм, журамд өөрөөр заагаагүй тохиолдолд ОУХБХ, АХБХ болон Холбооны дүрэм, журам, шийдвэр болон зааврыг тайлбарлах, хэрэглэх асуудлаар Шүүхэд хандахгүй гэсэн амлалт;
- 3.5. Энэ Дүрэмд заасан Швейцарийн Лозанна хотноо төвтэй Олон улсын спортын арбитрын шүүхийг (CAS) эсвэл МХБХ-ны хүлээн зөвшөөрсөн үндэсний арбитрыг хүлээн зөвшөөрч байгаа тухай мэдэгдэл;
- 3.6. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- 3.7. Талбайн эзэн багийн албан ёсны бүх тоглолтоо Монгол Улсын нутаг дэвсгэрт явуулах тухай амлалт;
- 3.8. Гишүүнээр элсэх хүсэлт гаргасан хуулийн этгээд нь эрх зүйн хувьд гадны ямар нэгэн нөлөөгүйгээр бие даан шийдвэр гаргах чадвартай гэсэн тодорхойлолт;
- 3.9. Гуравдагч этгээдтэй байгуулах хууль зүйн гэрээ, хэлцэлд гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтны нэрсийн жагсаалт;
- 3.10. Холбоотой урьдчилан зөвшилцсөний үндсэн дээр нөхөрсөг тоглолт зохион байгуулах буюу нөхөрсөг тоглолтод оролцоно гэсэн амлалт;
- 3.11. Өөрийн эрх барих дээд байгууллагын хамгийн сүүлд хуралдсан хурлын тэмдэглэлийн хуулбар;
- 3.12. Хөгжлийн хөтөлбөр;
- 3.13. Аудит ба санхүүгийн тайлан;
- 3.14. Сүүлийн 2 жил МХБХ-ны үйл ажиллагаанд хамрагдсанг батлах бичиг;
- 3.15. Клуб бүртгүүлэх тохиолдолд Клуб Лицензжүүлэх дүрмийн дагуу шаардлага хангасан лицензтэй байх. (А, В, С лиценз);

4. Энэ зүйл нэгэнт элссэн гишүүдийн эрх зүйн байдалд нөлөөлөхгүй.

11-р зүйл. Хүсэлт болон гишүүнээр элсүүлэх журам

1. Гишүүнээр элсүүлэх үйл ажиллагааг Холбооны Зөвлөлөөс баталсан тусгай журмаар зохицуулна.
2. Шинэ гишүүнийг хүлээн зөвшөөрөх эсэх асуудлыг Зөвлөлийн санал болгосноор Их хурал шийдвэрлэнэ. Гишүүнээр элсэх болсон шалтгаанаа Их хуралд мэдүүлнэ.
3. Шинэ гишүүн нь Их хурлаар хүлээн зөвшөөрөгдсөн үеэс эхлэн Холбооны гишүүнчлэлийн эрх ба үүрэг үүснэ.

12-р зүйл. Гишүүний эрх

1. Холбооны гишүүд дараах эрхийг эдэлнэ. Үүнд:
 - 1.1. Их Хуралд оролцох, хэлэлцэх асуудалтай урьдчилж танилцах, товлосон хугацаанд Их Хуралд дуудагдах, санал өгөх эрхээ эдлэх,
 - 1.2. Их Хурлаар хэлэлцэх асуудлын талаар санал гаргах, хуралдаанд оролцох, санал өгөх,
 - 1.3. Холбооны бүх байгууллагын сонгуульд нэр дэвшүүлэх,
 - 1.4. Холбооны үйл ажиллагааны талаар тус Холбооны эрх бүхий байгууллагаас мэдээлэл авах,
 - 1.5. Холбооноос зохион байгуулж буй бүхий л тэмцээн, уралдаан болон спортын бусад арга хэмжээнд оролцох,
 - 1.6. Холбооны дүрэм, журамд тусгагдсан бусад эрх.

2. Дээр дурдсан эрхийг хэрэгжүүлэхэд энэхүү Дүрмийн бусад заалт болон холбогдох журмыг удирдлага болгоно.

13-р зүйл. Гишүүний үүрэг

1. Холбооны гишүүд дор дурдсан үүргийг хүлээнэ. Үүнд:
 - 1.1. ОУХБХ, АХБХ тэдгээрийн байгууллагууд болон Холбооны Дүрэм, журам, заавар болон шийдвэрийг биелүүлэх, хүндэтгэн сахих;
 - 1.2. Шийдвэр гаргах эрх бүхий байгууллагуудаа 4-өөс доошгүй жилд нэг удаа сонгох;
 - 1.3. Байгууллагынхаа эрх барих дээд байгууллагын хурлыг тогтмол жилд нэг удаа аль эсвэл тодорхой нөхцөлд 2 жилд нэгээс доошгүй удаа тус тус хуралдуулах;
 - 1.4. Холбооноос зохион байгуулах тэмцээн болон спортын бусад арга хэмжээнд оролцох;
 - 1.5. Гишүүний татвараа төлөх;
 - 1.6. Олон Улсын Хөлбөмбөгийн Холбооны Зөвлөлөөс баталсан Тоглолтын Дүрэм ба ОУХБХ-ноос баталсан Футзал, Элсний хөлбөмбөгийн Дүрмүүдийг өөрөө болон гишүүдээрээ сахин мөрдүүлэх;
 - 1.7. ОУХБХ-ны дүрэм ба энэхүү дүрэмд заасны дагуу ОУХБХ, АХБХ болон Холбооны дүрэм, журам, заавар болон шийдвэртэй холбогдох тухайн гишүүн буюу өөр гишүүнийг хамарсан аливаа маргааныг Холбоонд хүлээн зөвшөөрөгдсөн Үндэсний Арбитрт гаргах, Холбоо нь Үндэсний Арбитргүй бол зөвхөн Швейцарь улс дахь Лозанна хотод байрладаг Спортын Арбитрын Шүүхээр шийдвэрлүүлэх гэсэн заалтыг өөрийн дүрэмдээ тусгах мөн уг асуудлаар Шүүхэд хандахыг хориглох;
 - 1.8. Өөрийн дотоод дүрэм, журамд нэмэлт, өөрчлөлт оруулсан мөн гуравдагч этгээдтэй байгуулах хууль зүйн заавал биелүүлэх гэрээ, хэлцэлд гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтны нэрсийн жагсаалтад өөрчлөлт орсон тохиолдолд Холбоонд нэн даруй мэдэгдэх;
 - 1.9. Их хурлаас хүлээн зөвшөөрөөгүй болон гишүүнчлэлийг нь түдгэлзүүлсэн эсвэл гишүүнээс чөлөөлөгдсөн байгууллага, хувь хүмүүстэй спортын харилцааг тогтоохгүй байх;
 - 1.10. Шударга тоглолтын илэрхийлэл болсон тууштай үнэнч, эв нэгдэл, спортын сахилгыг зарчмуудыг өөрийн дүрэмд тусгаж мөрдөх;
 - 1.11. Гишүүнийхээ хугацаанд Дүрмийн 10 дугаар зүйлийн 3-р заалтыг бүрэн биелүүлэх;
 - 1.12. Гишүүд нь өөрийн гишүүний бүртгэлийг хөтөлж тухай бүрд шинэчлэх, шинэчилсэн тухайгаа тухай бүрд Холбоонд бичгээр мэдэгдэх;
 - 1.13. Өөрийн дүрмийг Холбооны Дүрмийн шаардлагад нийцүүлэн батлах;
 - 1.14. ОУХБХ, АХБХ болон Холбооны Дүрэм, журамд заасан бусад үүргийг дагаж мөрдөх;
 - 1.15. ОУХБХ-ны дүрмийн дагуу Шигшээ багт дуудагдсан тоглогчдыг нэн даруй шигшээ багийн бэлтгэлд хамрагдахыг зөвшөөрөх.
2. Дээр дурдсан үүргийг зөрчсөн гишүүнд энэ Дүрэмд заасны дагуу шийтгэл ногдуулна.

14-р зүйл. Гишүүнчлэлийг түдгэлзүүлэх

1. Гишүүнчлэлийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг Их хурал шийдвэрлэнэ. Гэхдээ Гишүүн үүргийн ноцтой зөрчил гаргасан тохиолдолд Зөвлөл гишүүнчлэлийг түдгэлзүүлэх шийдвэр гаргаж болно. Ийнхүү түдгэлзүүлсэн нь Зөвлөл уг шийдвэрийг цуцлаагүй тохиолдолд дараагийн Их хурал хүртэл хүчинтэй хэвээр байна.
 2. Гишүүнчлэлийг түдгэлзүүлснийг дараагийн Их хурлаар хуралд оролцсон, санал өгөх эрхтэй нийт гишүүдийн гуравны хоёрын саналаар баталгаажуулна. Ийнхүү баталгаажуулаагүй тохиолдолд гишүүнчлэлийг түдгэлзүүлсэн нь шууд цуцлагдана.
 3. Гишүүнчлэлийг түдгэлзүүлсэн нөхцөлд гишүүний эрх дуусгавар болно. Холбооны бусад гишүүд гишүүнчлэлийг түдгэлзүүлсэн гишүүнтэй спортын чиглэлээр харилцаа хөгжүүлэхгүй. Гишүүнчлэлийг түдгэлзүүлсэн тохиолдолд өөр бусад шийтгэлийг мөн Сахилгын хорооноос ногдуулж болно.
 4. Холбооноос зохион байгуулдаг үйл ажиллагаанд хоёр жил дараалан оролцоогүй гишүүн нь ээлжит Их Хуралд санал өгөх эрхгүйгээр оролцох бөгөөд уг үүргээ биелүлтэл тухайн гишүүний төлөөлөл нь сонгогдох ба томилогдох эрх эдлэхгүй болно.
-

15-р зүйл. Гишүүнээс чөлөөлөх

Их хурал дараах шалтгаанаар гишүүнээс чөлөөлнө. Үүнд:

1. Холбооны өмнө хүлээсэн санхүүгийн үүргээ биелүүлээгүй;
 2. ОУХБХ, АХБХ болон Холбооны дүрэм, журам, заавар эсхүл шийдвэрийг ноцтойгоор зөрчсөн;
 3. ОУХБХ, АХБХ болон Холбооны холбогдох эрх зүйн актад тусгайлан зааснаас бусад тохиолдолд маргаантай асуудлаар Шүүхэд хандсан тохиолдолд;
 4. Гишүүнээс хасах асуудлыг санал өгөх эрхтэй Их хурлын төлөөлөгчдийн ирц олонх (50 хувиас дээш) байж хэлэлцэх бөгөөд шийдвэр нь төлөөлөгчдийн гуравны хоёрын саналаар хүчин төгөлдөр болно.
-

16-р зүйл. Гишүүнчлэлээс татгалзах

1. Гишүүд нь Холбооны гишүүнчлэлээс татгалзаж болох ба энэ шийдвэр нь тухайн оны хөлбөмбөгийн улирлын төгсгөлд хэрэгжиж эхэлнэ. Гишүүнээс татгалзах өргөдлөө Хөлбөмбөгийн улирал дуусахаас 6 сарын өмнө Холбооны Ерөнхий нарийн бичгийн даргын газарт хүргүүлсэн байна.
 2. Холбоо болон бусад гишүүдийн өмнө хүлээсэн санхүүгийн үүргээ дуусгавар болгосон нөхцөлд гишүүнчлэлээс татгалзах асуудал эцэслэн шийдвэрлэгдэнэ.
-

17-р зүйл. Гишүүд болон тэдгээрийн байгууллагуудын бие даасан байдал

1. Гишүүн бүр бие дааж, гуравдагч этгээдийн нөлөөнд үл автан үйл ажиллагаагаа явуулна.
2. Холбооны гишүүд өөрийн дотоод байгууллагуудаа сонгож, томилох бөгөөд гишүүд дүрэмдээ энэ эрхээ бие дааж хэрэгжүүлэхээ баталгаажуулна.

3. Уг зүйлийн 2-т заасны дагуу сонгогдож томилогдоогүй байгууллагыг Холбоо хүчин төгөлдөрт тооцохгүй.

18-р зүйл. Клуб, Лиг, Орон нутгийн хөлбөмбөгийн холбоо болон бусад клубүүдийн нэгдлийн эрх зүйн байдал

1. Клуб, Лиг, Орон нутгийн хөлбөмбөгийн холбоо болон бусад клубүүдийн нэгдэл нь Холбоогоор хүлээн зөвшөөрөгдөж, түүний удирдлага дор үйл ажиллагаагаа явуулна. Монгол Улсын хэмжээнд үндэсний мэргэжлийн нэг дээд Лиг байна. Орон нутгийн хөлбөмбөгийн холбоо, клубүүдийн эрх хэмжээ, эрх үүргийг энэхүү дүрмээр тодорхойлж Их Хурлаар баталсан Жишиг дүрмийн дагуу МХБХ дүрмийг батална. Шүүгч, сахилгын хороонд хамааралтай асуудал, сэргээш, клуб лицензжүүлэх болон тоглогчийн бүртгэл, шилжилт хөдөлгөөнтэй хамааралтай асуудлыг Холбооны бүрэн эрх мэдлийн хүрээнд шийдвэрлэнэ.
2. Клуб, Орон нутгийн хөлбөмбөгийн холбоо, албан ёсны гишүүнчлэлтэй холбоод нь аливаа гадны байгууллагаас үл хамааран бие даан шийдвэр гаргана. Энэ үүрэг нь зохион байгуулалтын бүтцээс үл хамааран бүх клуб, Орон нутгийн хөлбөмбөгийн холбоодод хамаатай болно.
3. Аливаа тоглолт, тэмцээний шударга байдал алдагдахаас сэргийлж хувь хүн болон хуулийн этгээд (үүнд үндсэн болон охин компаниуд багтана) нэгээс илүү клубийг хяналтдаа байлгахыг хориглоно.

III. ХҮНДЭТ ЕРӨНХИЙЛӨГЧ БОЛОН ХҮНДЭТ ГИШҮҮД

19-р зүйл. Хүндэт Ерөнхийлөгч болон Хүндэт гишүүд

1. Холбооны Их Хурлаас Хөлбөмбөгийн спортыг хөгжүүлэх үйлсэд онцгой гавьяа байгуулсан хувь хүнд Хүндэт Ерөнхийлөгч буюу Хүндэт гишүүний цол өргөмжлөлийг олгоно.
2. Зөвлөл энэ цол өргөмжлөлд нэр дэвшүүлнэ.
3. Хүндэт Ерөнхийлөгч эсвэл Хүндэт гишүүд Их Хуралд оролцоно. Тэд Их Хурлын хэлэлцүүлэгт санал өгөх эрхгүй байна.

IV. БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

20-р зүйл. Холбооны бүтцийн байгууллагууд

1. Холбооны Их Хурал нь Холбооны эрх барих дээд байгууллага мөн.
2. Холбооны Ерөнхийлөгч нь Холбоог албан ёсоор төлөөлнө.
3. Холбооны Зөвлөл нь стратеги ба бодлого тодорхойлох байгууллага мөн.

4. Байнгын болон Түр Хороод нь Зөвлөлд үүргээ биелүүлэхэд нь зөвлөж туслалцаа үзүүлнэ. Эдгээр хороодын үүрэг, бүрэлдэхүүн болон чиг үүргийг энэхүү Дүрэмд нийцүүлэн Зөвлөлөөс боловсруулсан тусгай журмаар тодорхойлно.
5. Ерөнхий нарийн бичгийн даргын газар нь захиргааны байгууллага мөн.
6. Сахилгын хороо, Ёс зүйн хороо болон Маргаан таслах хорооны үйл ажиллагаа нь Эрх зүйн байгууллагад хамаарна.
7. Холбооны байгууллагуудыг тус Дүрмийн дагуу ямар нэгэн хөндлөнгийн нөлөөгүйгээр, энэхүү Дүрмийн дагуу Холбооноос шууд сонгох буюу томилно. Холбооны бүтцийн байгууллагын гишүүд нь Монгол улсын хууль дүрмийн дагуу ямарваа нэг ял, шийтгэл эдэлж байгаагүй этгээд байна.
8. Клуб лицензжүүлэх системийг Клуб Лицензжүүлэх Байгууллага хариуцах бөгөөд тус байгууллага нь Холбоонд харьяалагдана.
9. Сонгуулийн хороо нь сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах болон хяналт тавих эрх бүхий байгууллага мөн.
10. Холбооны бүтцийн зураг Хавсралт №3-т заасны дагуу байна.
11. Ашиг сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлж, Холбооны байгууллагын аливаа гишүүн өөрт холбогдолтой асуудлыг шийдвэрлэхэд оролцохгүй байна.

А. ИХ ХУРАЛ

21-р зүйл. Их хурлын тодорхойлолт, түүний бүрэлдэхүүн

1. Их Хурал нь Холбооны гишүүдийн тогтмол хуралддаг эрх барих дээд байгууллага бөгөөд дүрмийн дагуу хуралдсан Их Хурлын шийдвэр нь хүчин төгөлдөр байх болно. Их Хурал нь ардчилсан, хөлбөмбөг дэх хүйсийн эрх тэгш байдлыг хангасан зарчмыг баримтална.
 2. Их Хурал нь ээлжит ба ээлжит бус байна.
 3. Их Хурлын үйл ажиллагааг Их Хурлын дэгийн дагуу Ерөнхийлөгч даргалан хуралдуулна.
-

22-р зүйл. Их хурлын төлөөлөгчид, санал хураалт

1. Их Хурал 52 төлөөлөгчөөс бүрдэнэ. Төлөөлөгчдийн тоог дараах хуваарийн дагуу тогтооно. Үүнд:

1.1. Орон нутгийн хөлбөмбөгийн холбоо (21 аймаг) тус бүрээс	1
1.2. Холбоонд бүртгэлтэй 24 Клуб тус бүрээс	1
1.3. Шүүгчдийн зөвлөл	1
1.4. Дасгалжуулагчдын зөвлөл	1
1.5. Эмэгтэй хөлбөмбөгийн зөвлөл	2
1.6. Ахмадын зөвлөл	2
1.7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөлбөмбөгийн зөвлөл	1
2. Их Хурлын төлөөлөгч Холбооны гишүүн байгууллагыг төлөөлж түүнд харьяалагдсан байх бөгөөд тэндээсээ сонгогдсон буюу томилогдсон байна. Шаардлагатай гэж үзвэл үүнийгээ баримтаар баталгаажуулах болно.
3. Төлөөлөгч бүр Их Хурлын санал хураалтад тэгш эрхтэй оролцоно. Их Хуралд зөвхөн өөрийн биеэр оролцсон төлөөлөгч санал өгөх эрхтэй. Санал өгөх эрхээ бусдад шилжүүлэх эсвэл албан бичгээр санал өгөхийг хориглоно.

4. Зөвлөлийн гишүүд болон Ерөнхий нарийн бичгийн дарга Их Хуралд санал өгөх эрхгүйгээр оролцоно. Зөвлөлийн гишүүд сонгуульт хугацаандаа харьяалагдах Холбооны гишүүн байгууллагаасаа Их Хуралд төлөөлөгчөөр сонгогдож үл болно.

23-р зүйл. Их хурлын бүрэн эрх

1. Их хурал дараах бүрэн эрхтэй байна. Үүнд:
 1. Холбооны Дүрэм батлах, нэмэлт өөрчлөлт оруулах;
 2. Өмнөх хурлын тэмдэглэлийг хянах, батлах 3 гишүүнийг томилох;
 3. Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгчид болон Зөвлөлийн гишүүдийг сонгох, чөлөөлөх;
 4. Эрх зүйн байгууллагуудын дарга болон гишүүдийг сонгох;
 5. Тооллогын комиссын гишүүдийг томилох;
 6. Санхүүгийн тайланг батлах;
 7. Төсөв батлах;
 8. Ажлын тайланг батлах;
 9. Зөвлөлийн санал болгосон хөндлөнгийн аудиторыг сонгох ба чөлөөлөх;
 10. Зөвлөлийн саналын дагуу Холбооны гишүүдийн татварын хэмжээг тогтооно;
 11. Зөвлөлөөс Хүндэт Ерөнхийлөгч, Хүндэт гишүүн цол өргөмжлөл олгохоор нэр дэвшүүлсэн саналыг шийдвэрлэх;
 12. Гишүүнчлэлийг түдгэлзүүлэх болон гишүүнээс хасах асуудлыг шийдвэрлэх;
 13. Холбооны байгууллагын нэг буюу хэд хэдэн гишүүний бүрэн эрхийн хугацааг дуусгавар болгох;
 14. Холбоог татан буулгах;
 15. Гишүүн байгууллагаас гаргасан хүсэлтийг Дүрмийн дагуу шийдвэрлэх;
 16. Сонгуулийн хороо, Сонгуулийн Хяналтын хорооны гишүүдийг сонгох ба чөлөөлөх;
 17. Клубийг лицензжүүлэх байгууллагын гишүүдийг сонгох ба чөлөөлөх;
 18. Зөвлөлийн саналаар Аудит ба Хяналт шалгалтын хорооны гишүүдийг сонгох ба чөлөөлөх;

24-р зүйл. Их хурлын ирц

1. Их Хуралд санал өгөх эрхтэй гишүүдийн ирц олонх (50 хувиас дээш)-ид хүрсэн тохиолдолд Их Хурлаас гарах шийдвэр хүчин төгөлдөр байна.
2. Хурлын ирц олонход хүрээгүй тохиолдолд 24 цагийн дотор Их Хурлаа дахин хуралдуулж болно.
3. Холбооны Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгчид, Зөвлөлийн гишүүдийг сонгох, Холбооны байгууллагын нэг буюу хэд хэдэн гишүүнийг гишүүнээс чөлөөлөх болон Холбоог татан буулгах зэрэг асуудлаас бусад аливаа асуудлыг хэлэлцэхэд хоёр дахь удаагийн Их Хурлын ирц олонх байх шаардлагагүй.

25-р зүйл. Их хурлын шийдвэр

1. Тухайн асуудлыг шийдвэрлэхэд саналыг илээр буюу цахим төхөөрөмжөөр хураана. Ил санал хураалтаар олонх болсон гэж тодорхойлоход хүндрэлтэй байвал Хурлын төлөөлөгчдийн нэрсийг цагаан толгойн дарааллын дагуу дуудаж санал хураана.
 2. Энэхүү Дүрэмд өөрөөр заагаагүй бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр болоход олонхийн санал (50 хувиас дээш) байхад хангалттай. Олонх болсныг тогтоохдоо хоосон ба хүчингүй болсон, түдгэлзсэн саналын хуудас болон цахим төхөөрөмжөөр будлиан үүсгэсэн саналыг хасч тооцно.
-

26-р зүйл. Сонгууль

1. Сонгуулийг нэр дэвшүүлж явуулна. Сонгуулийг нууц санал хураалтаар явуулна. Нэр дэвшигчийн тоо мандатын тоотой тохирсон тохиолдолд нэр дэвшигчдийг шууд батална.
2. Холбооны сонгууль, Холбооны гишүүдийн сонгуулийг дүрэмд өөрөөр заагаагүй бол Холбооны Сонгуулийн дүрмийн дагуу Сонгуулийн хороо явуулна.
3. Зөвлөлийн гишүүдийн сонгуулийг дараах дарааллаар явуулна. Ерөнхийлөгч, 2 Дэд Ерөнхийлөгч, зөвлөлийн гишүүд, зөвлөлийн эмэгтэй гишүүн, Орон нутгийн холбоодоос сонгогдсон гишүүнийг батламжлах, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөлбөмбөгийн зөвлөлөөс сонгогдсон гишүүнийг шууд батламжлах. Үүнд:
 - a. **Ерөнхийлөгч:** Ерөнхийлөгчийг хүчин төгөлдөр олонхийн (50 хувиас дээш) саналаар сонгоно. Эхний санал хураалтаар аль нэг нэр дэвшигч нь санал өгсөн гишүүдийн 50 хувиас дээш саналыг авч чадахгүй байх тохиолдолд хоёр дахь санал хураалтыг явуулна. Хоёр дахь санал хураалтаар хамгийн бага санал авсан нэр дэвшигч хасагдаж, энгийн олонхийн санал авсан нэр дэвшигч сонгогдоно.
 - b. **Дэд Ерөнхийлөгч:** Дэд ерөнхийлөгчийг хүчин төгөлдөр олонхийн (50 хувиас дээш) саналаар сонгоно. Эхний санал хураалтаар аль нэг нэр дэвшигч нь санал өгсөн гишүүдийн 50 хувиас дээш саналыг авч чадахгүй байх тохиолдолд хоёр дахь санал хураалтыг явуулна. Хоёр дахь санал хураалтаар хамгийн бага санал авсан нэр дэвшигч хасагдаж, энгийн олонхийн санал авсан нэр дэвшигч сонгогдоно.
 - c. **Эмэгтэй дэд ерөнхийлөгч:** Эмэгтэй дэд ерөнхийлөгчийг хүчин төгөлдөр олонхийн (50 хувиас дээш) саналаар сонгоно. Эхний санал хураалтаар аль нэг нэр дэвшигч нь санал өгсөн гишүүдийн 50 хувиас дээш саналыг авч чадахгүй байх тохиолдолд хоёр дахь санал хураалтыг явуулна. Хоёр дахь санал хураалтаар хамгийн бага санал авсан нэр дэвшигч хасагдаж, энгийн олонхийн санал авсан нэр дэвшигч сонгогдоно.
 - d. **Зөвлөлийн бусад гишүүн:** Санал авсан эрэмбийн дагуу үлдсэн суудалд сонгогдоно.
 - e. **Эмэгтэй гишүүн:** Эмэгтэй гишүүнийг хүчин төгөлдөр олонхийн (50 хувиас дээш) саналаар сонгоно. Эхний санал хураалтаар аль нэг нэр дэвшигч нь санал өгсөн гишүүдийн 50 хувиас дээш саналыг авч чадахгүй байх тохиолдолд хоёр дахь санал хураалтыг явуулна. Хоёр дахь санал хураалтаар хамгийн бага санал авсан нэр дэвшигч хасагдаж, энгийн олонхийн санал авсан нэр дэвшигч сонгогдоно.

- f. Орон нутгийн төлөөлөл:** Орон нутгийн төлөөллийг Их хуралд оролцож буй 21 аймгийн төлөөлөгчдийн өгсөн саналаас хамгийн өндөр санал авсан нэр дэвшигчийг сонгоно. Тухайн нэр дэвшигчийг тус Их Хурал дээр батламжлана.
 - g. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөлбөмбөг:** Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөлбөмбөгийн зөвлөл нь өөрийн дүрмийн дагуу төлөөллөө сонгох бөгөөд Холбооны Их хурлаар батламжлуулна.
- 4. Холбооны бусад байгууллагын Дарга, Орлогч дарга болон Гишүүдийг хамгийн их санал авсан дарааллаар сонгоно.
 - 5. Санал тэнцсэн тохиолдолд санал хураалтыг тус зүйлд заасны дагуу дахин явуулна.
 - 6. Холбооны бүтцийн байгууллагад нэр дэвшиж буй тухайн нэр дэвшигч сонгуульт их хурал болохоос 30 хоногоос багагүй хугацааны өмнө Холбооны Ерөнхий Нарийн Бичгийн даргын газарт нэр дэвших өргөдлөө өгнө. Сонгуульт Их Хурал болохоос 10 хоногоос багагүй хугацааны өмнө Холбооны гишүүдэд нэр дэвшигчдийн нэрсийг хүргүүлсэн байна.

27-р зүйл. Ээлжит Их Хурал

- 1. Ээлжит Их Хурал жил тутам хуралдана.
- 2. Их Хурал болох өдөр, газрыг Зөвлөлөөс товлон. Их Хурлын зарыг хуралдахаас 45 хоногийн өмнө гишүүдэд албан ёсоор мэдэгдэнэ.
- 3. Их Хурал болохоос 10 хоногийн өмнө хурлаар хэлэлцэх асуудал, ажлын тайлан, санхүүгийн болон аудитын тайлан, бусад холбогдох бичиг баримтыг Холбооны гишүүдэд хүргүүлнэ.

28-р зүйл. Ээлжит Их Хурлаар хэлэлцэх асуудал

- 1. Ерөнхий нарийн бичгийн дарга нь Зөвлөл болон гишүүдээс ирүүлсэн саналыг үндэслэж Их Хурлаар хэлэлцэх асуудлыг боловсруулна. Гишүүд Их Хурлаар хэлэлцүүлэх аливаа саналаа бичгээр товч тайлбарын хамт Ерөнхий нарийн бичгийн газарт Их Хурал болохоос 30 хоногийн өмнө ирүүлнэ.
- 2. Их Хурал дараах асуудлыг дарааллын дагуу хэлэлцэнэ. Үүнд:
 - 2.1. Холбооны Их хурлыг Холбооны дүрмийн дагуу хүчин төгөлдөр болж буйг мэдэгдэх;
 - 2.2. Хэлэлцэх асуудлыг батлах;
 - 2.3. Ерөнхийлөгч үг хэлэх;
 - 2.4. Хурлын тэмдэглэл хянах гишүүдийг томилох;
 - 2.5. Тооллогын комиссын гишүүдийг томилох;
 - 2.6. Гишүүнээс түдгэлзүүлэх болон чөлөөлөх тухай асуудал;
 - 2.7. Өмнөх хурлын тэмдэглэлийг батлах;
 - 2.8. Ерөнхийлөгчийн ажлын тайлан; (өмнөх Их хурлаас хойш хийсэн ажлын тайлан);
 - 2.9. Санхүүгийн тайлан тэнцлийг танилцуулах;
 - 2.10. Санхүүгийн тайланг батлах;

- 2.11. Гишүүнээр батлах;
- 2.12. Төсөв батлах;
- 2.13. Холбооны дүрэм, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах талаар санал хураах;
- 2.14. Энэ зүйлийн 1-т заасны дагуу Холбооны гишүүд болон Зөвлөлдөх зөвлөлөөс гаргасан саналыг хэлэлцэх;
- 2.15. Зөвлөлийн саналын дагуу хөндлөнгийн аудиторыг томилох (шаардлагатай бол);
- 2.16. Холбооны байгууллагыг татан буулгах;
- 2.17. Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгчид, Зөвлөлийн гишүүдийг сонгох;
- 2.18. Эрх зүйн байгууллагуудын гишүүдийг сонгох;
- 2.19. Аудит ба Хяналт шалгалтын хорооны гишүүдийг сонгох (шаардлагатай бол);
- 2.20. Сонгуулийн Хороо, Сонгуулийн хяналтын хорооны гишүүдийг сонгох;
- 2.21. Бусад

3. Хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй зүйлийг Их Хурал хэлэлцэхгүй. Гэхдээ санал өгөх эрхтэй төлөөлөгчдийн гуравны хоёрын саналаар ээлжит Их Хурлын хэлэлцэх асуудалд өөрчлөлт оруулан хэлэлцэж болно.

29-р зүйл. Ээлжит бус Их хурал

1. Зөвлөл шаардлагатай тохиолдолд ээлжит бус Их Хурлыг хуралдуулж болно.
2. Холбооны гишүүдийн гуравны хоёроос дээш гишүүдийн албан ёсоор ирүүлсэн хүсэлтийг үндэслэн Зөвлөл ээлжит бус Их Хурлыг хуралдуулна. Гишүүд тавьсан хүсэлтэндээ хэлэлцэх асуудлыг тодорхой заана. Хүсэлтийг хүлээн авснаас хойш нэг сарын хугацаанд ээлжит бус Их Хурлыг хуралдуулна. Хэрвээ ээлжит бус Их Хурлыг хуралдуулахгүй тохиолдолд хүсэлт гаргасан гишүүдийн төлөөлөгчид өөрсдөө ээлжит бус Их Хурлыг хуралдуулж болно. Хүсэлт гаргасан гишүүдийн төлөөлөгчид мөн Олон улсын Хөлбөмбөгийн Холбоо /FIFA/ болон Азийн Хөлбөмбөгийн Холбоо /AFC/-ноос туслалцаа хүсч болно.
3. Ээлжит бус Их Хурал хуралдуулах хугацаа, газар болон зорилгын тухай нийт гишүүдэд хурал эхлэхээс 14 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.
4. Ээлжит бус Их Хурлыг Зөвлөлийн санаачилгаар хийх тохиолдолд хэлэлцэх асуудлыг Зөвлөл боловсруулна. Харин ээлжит бус Их Хурлын гишүүдийн хүсэлтээр хуралдуулах тохиолдолд, хэлэлцэх асуудалд тэдний саналыг тусгах ёстой.
5. Ээлжит бус Их Хурлын хэлэлцэх асуудалд өөрчлөлт оруулахгүй.

30-р зүйл. Холбооны дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах

1. Их хурал нь дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах эрх, үүрэгтэй бөгөөд, хэрэв боломжтой бол нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудлыг хариуцна.
2. Гишүүд болон Зөвлөл холбооны Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах саналаа бичгээр гаргаж товч тайлбарын хамт Ерөнхий нарийн бичгийн даргын газарт хүргүүлнэ. Гишүүнээс гаргаж буй санал нь гурваас доошгүй гишүүд дэмжиж түүнийгээ бичгээр илэрхийлсэн тохиолдолд хүчин төгөлдөр болно.
3. Дүрэмд орох нэмэлт, өөрчлөлт нь санал өгөх эрхтэй төлөөлөгчдийн олонхоор (50 хувиас дээш) хүчинтэй болно.

4. Холбооны дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал нь хуралд оролцсон, санал өгөх эрхтэй нийт гишүүдийн ердийн олонхийн (50 хувиас дээш) саналаар дэмжигдэж батлагдана.

31-р зүйл. Хурлын тэмдэглэл

1. Их хурлын тэмдэглэл хөтлөлтийг Ерөнхий нарийн бичгийн дарга хариуцан хөтөлнө. Томилогдсон гишүүд Их Хурлын тэмдэглэлийг хянаж дараагийн Их хурлаар баталгаажуулна.

32-р зүйл. Шийдвэр хүчин төгөлдөр болох хугацаа

1. Энэхүү Дүрэмд өөрөөр заагаагүй эсвэл Их хурал шийдвэр хүчин төгөлдөр болох өөр хугацаа тогтоогоогүй тохиолдолд Их хурлаас гаргасан шийдвэр нь уг Их хурал дуусмагц хүчин төгөлдөр болж гишүүдэд үйлчилнэ.

Б. ЗӨВЛӨЛ

33-р зүйл. Бүрэлдэхүүн

1. Зөвлөл 15 гишүүнтэй байна. Үүнд:
 - а. Ерөнхийлөгч-1
 - б. Дэд ерөнхийлөгч-2 (2 Дэд Ерөнхийлөгчийн нэг нь эмэгтэй байна.)
 - в. Гишүүн-9
 - г. Эмэгтэй гишүүн-1
 - д. Орон нутгийн төлөөлөл-1
 - е. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөлбөмбөгийн зөвлөл-1
2. Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгчид болон Зөвлөлийн бусад гишүүд тус дүрмийн 26-р зүйлд заасны дагуу сонгогдож батламжлагдана. Орон нутгийн төлөөлөл болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөлбөмбөгийн төлөөллөөс бусад нэр дэвшигчдийг 5-аас цөөнгүй гишүүн байгууллага нэр дэвшүүлнэ. Орон нутгийн төлөөлөлд нэр дэвшигчийг 3-аас цөөнгүй гишүүн байгууллагаас нэр дэвшүүлнэ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөлд нэр дэвшигч нь өөрийн дүрэм журамд заасны дагуу нэр дэвшинэ.
3. Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгчид болон Зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 4 жил байна. Бүрэн эрхийн хугацаа тухайн сонгуулиар сонгогдсон даруйд хүчин төгөлдөр болно. Ерөнхийлөгч 1 удаа улиран сонгогдож болно. Зөвлөлийн бусад гишүүд улиран сонгогдож болно.
4. Зөвлөлийн гишүүн нь 18-аас дээш настай байх бөгөөд хөлбөмбөгийн спортод 4-өөс доошгүй жил идэвхтэй оролцсон, Холбооны 5-аас доошгүй гишүүн байгууллага нэр дэвшихийг дэмжиж санал болгосон, Монгол улсын хууль тогтоомжийг зөрчиж, гэмт хэрэгт холбогдоогүй, Монгол улсын нутаг дэвсгэрт байнга оршин суудаг иргэн байна.

5. Зөвлөлийн гишүүн нь Аудит, Хяналтын хороо, Их хурлын төлөөлөгч, эсвэл Холбооны эрх зүйн байгууллагуудын гишүүнээр давхар томилогдон ажиллахыг хориглоно.
6. Зөвлөлийн гишүүдийн 50 хүртэлх хувь нь орон гарсан тохиолдолд Зөвлөл нь ээлжит болон ээлжит бус Их Хурлаар ижил шалгуурын дагуу дутуу гишүүдийн тоог орон гарсан гишүүний бүрэн эрхийнх нь хугацаагаар нөхөж сонгоно.
7. Зөвлөлийн гишүүн нь нас барсан, хөдөлмөрийн чадвараа алдсан эсвэл хуралдаанд гурван удаа дараалан оролцоогүй бол гишүүний бүрэн эрх дуусгавар болсонд тооцно.
8. Зөвлөлийн гишүүдийн 50 хувиас дээш хувь нь орсон гарсан тохиолдолд Шуурхай зөвлөл нь ээлжит бус Их Хурал зарлаж үлдсэн бүрэн эрхийн хугацааны дахин сонгууль явуулна. Шуурхай зөвлөлийн хурлын ирц бүрэлдэхгүй байх тохиолдолд Ерөнхий нарийн бичгийн даргын газар ээлжит бус Их Хурлыг тодорхой заасан хугацаанд хуралдуулна.

34-р зүйл. Хуралдаан

1. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.
2. Зөвлөлийн хуралдаан нь ээлжит болон ээлжит бус байна.
3. Зөвлөлийн ээлжит хуралдаан нь улиралд нэг удаа хуралдана. Ерөнхийлөгч ээлжит хуралдааныг зарлан хуралдуулж даргална.
4. Зөвлөлийн ээлжит бус хурлыг нийт гишүүдийн 50 хувь нь хуралдаан зарлах хүсэлт гаргасан тохиолдолд Ерөнхийлөгч 21 хоногийн дотор хуралдааныг зарлан хуралдуулна. Хэрэв Ерөнхийлөгч энд дурдсан хугацаанд хуралдааныг зарлан хуралдуулахгүй бол Зөвлөлийн гишүүд хуралдааныг зарлан хуралдуулна.
5. Ерөнхийлөгч хуралдааны хэлэлцэх асуудлыг тодорхойлно. Зөвлөлийн гишүүн бүр хэлэлцэх асуудлын талаар санал өгөх эрхтэй. Зөвлөлийн гишүүд хэлэлцэх асуудалд оруулах саналаа Ерөнхий нарийн бичгийн даргын газарт хурал болохоос 14 хоногийн өмнө ирүүлсэн байна. Хэлэлцэх асуудлыг хуралдаан болохоос 7 хоногийн өмнө Зөвлөлийн гишүүдэд хүргүүлнэ.
6. Ерөнхий нарийн бичгийн дарга Зөвлөлийн хуралдаанд зөвлөх үүрэгтэй оролцоно.
7. Зөвлөлийн хуралдаан хаалттай явагдана. Зөвлөлийн хуралдаанд гуравдагч этгээдийг урьж оролцуулж болно. Уг гуравдагч этгээд нь санал өгөх эрхгүй байх бөгөөд зөвхөн Зөвлөлийн зөвшөөрлөөр санал бодлоо илэрхийлж оролцоно.

35-р зүйл. Зөвлөлийн бүрэн эрх

1. Зөвлөл нь Холбооны эрхэм зорилго, бодлого, стратегийн чиглэл, үнэт зүйлсийг тодорхойлно;
2. Холбооны Ээлжит болон Ээлжит бус Их Хурлын бэлтгэлийг хангаж хуралдуулна;
3. Их хурлаас сонгогддог Байнгын хорооны дарга, орлогч дарга болон гишүүнийг МХБХ-ны гишүүд эсвэл Ерөнхийлөгчийн санал болгосноор томилох;
4. Шаардлагатай үед Түр Хороо байгуулах шийдвэр гаргаж болно;
5. Байнгын болон Түр Хороодын ажиллах журмыг батална;
6. Ерөнхийлөгчийн санал болгосноор Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох эсвэл чөлөөлөх;
7. Их Хуралд хөндлөнгийн аудиторыг санал болгох;

8. Холбооны тэмцээнүүдийн зохион байгуулалт ба тэдгээрт оролцох нөхцлийг зааж өгсөн журмыг гаргана. Энэ нь Их хурлын бүтэц, зохион байгуулалтад нөлөөлөхөөргүй байна;
 9. Шигшээ багийн дасгалжуулагч болон техникийн бусад бүрэлдэхүүнийг томилох;
 10. МХБХ-ны дотоод бүтэц, зохион байгуулалтыг тодорхойлсон журам батална;
 11. Холбооны Дүрмийн хэрэгжилтийг хангуулах, түүнийг хэрэгжүүлэхэд авах шаардлагатай арга хэмжээг батална;
 12. Ээлжит Их Хурал хүртэл түр хугацаагаар хувь хүнийг чөлөөлөх ба Холбооны байгууллагыг татан буулгах эсвэл Холбооны гишүүн байгууллагыг гишүүнчлэлээс чөлөөлж болно;
 13. Зөвлөлийнхөө эрх хэмжээнд Холбооны бусад байгууллага ба гуравдагч этгээдэд үүрэг даалгавар өгч болно;
 14. Их Хурлын хэлэлцүүлэгт оролцох ба санал өгөх эрхгүй ажиглагчдыг томилж болно;
 15. Их хурал болох хүртэл эрх зүйн байгууллага болон Аудит ба Хяналт шалгалтын хорооны дутуу гишүүдийг томилно.
-

36-р зүйл. Зөвлөлийн шийдвэрүүд

1. Зөвлөлийн хуралдааны ирц 8 -аас доошгүй байх нөхцөлд тус хурлын хэлэлцүүлэг хүчинтэйд тооцно.
 2. Зөвлөлийн шийдвэрийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар (50 хувиас дээш) батална. Санал тэнцсэн үед Ерөнхийлөгчийн саналаар шийдвэрлэнэ. Санал өгөх эрхийг бусдад шилжүүлэх эсвэл албан бичгээр өгөхийг үл зөвшөөрнө.
 3. Ашиг сонирхлын зөрчил гарах магадлалтай тохиолдолд Зөвлөлийн гишүүн нь тухайн асуудал хэлэлцэх мөн шийдвэр гаргахаас татгалзаж болно.
 4. Хуралдаанаас гарсан шийдвэрүүдийг хурлын тэмдэглэлд тусгана.
 5. Зөвлөл нь өөрөөр тогтоогоогүй бол тухайн хуралдаанаас гарсан шийдвэрүүд нь тэр даруйд хүчин төгөлдөр болно.
-

37-р зүйл. Албан тушаалаас чөлөөлөх, байгууллага татан буулгах

1. Их Хурал нь хувь хүн эсвэл байгууллагын гишүүнийг чөлөөлж болно. Зөвлөл нь хувь хүнийг чөлөөлөх, байгууллагыг татан буулгах саналыг Их Хурлаар хэлэлцэх асуудалд оруулж болно. Зөвлөл нь түр хугацаагаар хувь хүнийг чөлөөлж, Холбооны байгууллагыг татан буулгаж болно. Зөвлөлийн гишүүн бүр хувь хүнийг чөлөөлөх, байгууллагыг татан буулгах тухай саналыг Их Хурал эсвэл Зөвлөлийн хурлын хэлэлцэх асуудалд оруулж болно.
2. Хувь хүнийг чөлөөлөх, байгууллагыг татан буулгах талаар санал гаргахад заавал шалтгаан, үндэслэлийг нь заан өгч түүнийгээ хэлэлцэх асуудлын хамт Зөвлөл ба Холбооны бүх гишүүдэд хүргэнэ.
3. Албан тушаалаас чөлөөлөгдөж буй хувь хүн, татан буугдаж буй байгууллага нь өөрийгөө өмгөөлөх эрхтэй.
4. Чөлөөлөх эсвэл татан буулгах тухай асуудлыг нууц санал хураалтаар явуулж гуравны хоёр (2/3) ын саналаар шийднэ.
5. Албан тушаалаасаа чөлөөлөгдсөн (түр), татан буугдсан (түр) этгээд нь ногдсон үүргээсээ нэн даруй чөлөөлөгдөнө.

V. ЕРӨНХИЙЛӨГЧ

38-р зүйл. Ерөнхийлөгч

1. Ерөнхийлөгч нь Холбоог албан ёсоор төлөөлнө.
2. Ерөнхийлөгч ажлын албатай байна. Ерөнхийлөгчийн ажлын албаны ажилтныг томилох, чөлөөлөх асуудлыг Ерөнхийлөгч шийдвэрлэнэ.
3. Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа 4 жил байх бөгөөд Сонгуульт Их хурал дуусмагц бүрэн эрх нь хүчин төгөлдөр болно. Ерөнхийлөгчийг 1 удаа улируулан сонгож болно.
4. Ерөнхийлөгчийн нэн тэргүүнд хариуцах асуудлууд. Үүнд:
 - 4.1. Ерөнхий нарийн бичгийн даргын газраар дамжуулан Их Хурал болон Зөвлөлөөс гарсан шийдвэрүүдийг хэрэгжүүлэх.
 - 4.2. Энэхүү Дүрмийн зорилтуудыг биелүүлэхийн тулд Холбооны байгууллагууд нь үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулж буй эсэхэд хяналт тавих.
 - 4.3. Ерөнхий нарийн бичгийн даргын газрын ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангаж, хяналт тавина
 - 4.4. Холбоо ба Холбооны гишүүн байгууллагууд, ОУХБХ, АХБХ, улс төр болон бусад байгууллага хоорондын харилцааг хариуцна.
5. Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох ба чөлөөлөх асуудлыг гагцхүү Ерөнхийлөгч санал болгоно.
6. Ерөнхийлөгч Их Хурал, Зөвлөлийн хуралдаан, Шуурхай зөвлөлийн хуралдааныг тус тус даргална.
7. Ерөнхийлөгч Зөвлөлийн хуралд эрх тэгш саналтай оролцоно. Санал тэнцсэн тохиолдолд Ерөнхийлөгчийн санал шийдвэрлэх үүрэгтэй байна.
8. Ерөнхийлөгч нас барсан, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан аль эсвэл Зөвлөлийн хуралдаанд дараалан 3 удаа оролцоогүй тохиолдолд Ерөнхийлөгчийн албан тушаал чөлөөлөгдсөнд тооцно.
9. Ерөнхийлөгчийн бусад бүрэн эрхийг Холбооны дотоод зохион байгуулалтын журамд тусгана.

39-р зүйл. Хууль ёсны төлөөлөл ба гарын үсэг

1. Ерөнхийлөгч нь Холбоог хууль ёсоор төлөөлж, байгууллагын нэрийн өмнөөс гарын үсэг зурна. Холбооны үйл ажиллагаатай холбоотой чухал бичиг баримтад хамтарсан гарын үсэг (ялангуяа Ерөнхийлөгчийн эзгүйд) зурахыг дотоод журмаар зохицуулна.

Д. ШУУРХАЙ ЗӨВЛӨЛ

40-р зүйл. Шуурхай зөвлөл

1. Шуурхай зөвлөл нь Зөвлөлийн ээлжит хуралдаан болохоос өмнө яаралтай шийдвэрлүүлэх асуудлуудыг хариуцна. Шуурхай зөвлөл нь Холбооны Ерөнхийлөгч болон Зөвлөлийн таван гишүүдээс бүрдэнэ. Эдгээр гишүүдийг Зөвлөл 4 жилийн хугацаагаар томилно.
2. Шуурхай зөвлөлийн хурлыг Ерөнхийлөгч зарлана. Хурлыг шаардлагатай хугацаанд хуралдуулах боломжгүй тохиолдолд захидал харилцааны бусад шугамыг ашиглаж

шийдвэрт хүрч болно. Шийдвэр нь гарсан даруйдаа хүчин төгөлдөр болно. Ерөнхийлөгч эдгээр шийдвэрүүдийг Зөвлөлд шуурхай танилцуулна.

3. Шуурхай зөвлөлийн хурлын ирц 3-аас доош гишүүнтэй байвал хурлын хэлэлцүүлэг хүчингүйд тооцно. Шуурхай зөвлөлийн гаргасан шийдвэрийг хуралд оролцсон гишүүдийн олонхын (50 хувиас дээш) саналаар батална. Санал тэнцсэн тохиолдолд Ерөнхийлөгч шийдвэрлэх саналтай байна.
4. Шуурхай зөвлөлийн гаргасан шийдвэрүүдийг Зөвлөлийн дараагийн хуралдаанаар батална.
5. Зөвлөлийн хуралд Ерөнхийлөгч биечлэн оролцох боломжгүй тохиолдолд Ерөнхийлөгчийн санал болгосон аль нэг Дэд ерөнхийлөгч хурлыг удирдана.

Г. БАЙНГЫН ХОРООД

41-р зүйл. Байнгын хороод

1. Холбоо нь дараах Байнгын Хороодтой байна. Үүнд:
 - 1.1. Санхүүгийн хороо;
 - 1.2. Аудит, Хяналт шалгалтын хороо;
 - 1.3. Тэмцээн зохион байгуулах хороо;
 - 1.4. Техник, Хөгжлийн Хороо;
 - 1.5. Шүүгчийн хороо;
 - 1.6. Эмэгтэйчүүдийн хөлбөмбөгийн хороо;
 - 1.7. Хүүхэд залуучуудын хөлбөмбөгийн хороо;
 - 1.8. Футзал ба элсний хөлбөмбөгийн хороо;
 - 1.9. Тоглогчдын эрх зүйн байдлын хороо;
2. Байнгын хороодыг Зөвлөлийн гишүүд даргална. Ерөнхийлөгч буюу Зөвлөл нь Холбооны гишүүдийн саналыг үндэслэж Байнгын хороо тус бүрийн гишүүдийг томилно.
3. Байнгын хороодын дарга, дэд дарга, гишүүд 4 жилийн хугацаагаар томилогдоно. Байнгын нэг хороонд хоёр хүртэлх Зөвлөлийн гишүүн байна.
4. Хороодын дарга тус бүр өөрийн хороог төлөөлөх бөгөөд Зөвлөлөөс боловсруулсан тухайн хороонд холбогдох Журамд заасны дагуу үйл ажиллагаагаа явуулна.
5. Байнгын хорооны дарга нь Ерөнхий нарийн бичгийн даргатай зөвшилцсөний үндсэн дээр хорооны хурлын товыг тогтоох бөгөөд ажлаа Зөвлөлд тайлагнана.
6. Байнгын хороод нь өөрийн журамдаа нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Зөвлөлөөр хэлэлцүүлж болно.

42-р зүйл. Санхүүгийн хороо

1. Тус хороо нь санхүүгийн менежментэд хяналт тавьж, санхүү болон хөрөнгийн менежменттэй холбогдох асуудлаар Зөвлөлд зөвлөж ажиллана. Тус хороо нь Холбооны төсөв болон Ерөнхий нарийн бичгийн даргын боловсруулсан санхүүгийн тайланд дүн шинжилгээ хийж Зөвлөлд танилцуулж батлуулна.
2. Тус Хороо нь дарга, орлогч дарга болон 2 гишүүнээс бүрдэнэ.

43-р зүйл. Аудит, хяналт шалгалтын хороо

1. Тус хороо нь санхүүгийн нягтлан бодох бүртгэлийн бүрэн гүйцэд, үнэн зөв эсэхийг хангах болон санхүүгийн тайлан, нэгдсэн санхүүгийн тайлан болон хөндлөнгийн аудиторын тайланг хянах үүрэгтэй.
2. Тус хороо нь Холбооны санхүү болон холбогдох бусад асуудалд хяналт тавихад, мөн Холбооны холбогдох журамд үнэн зөв нийцүүлсэн эсэхэд хяналт тавих асуудлаар Гүйцэтгэх Хороонд зөвлөж, туслалцаа үзүүлнэ.
3. Тус хорооны хариуцлага, дотоодын хамтын ажиллагаа болон үйл ажиллагаатай холбогдох бусад асуудлыг тус Холбооны холбогдох журмаар зохицуулна.
4. Тус хорооны дарга, орлогч дарга болон гишүүдийг Их хурлаас 4 жилийн хугацаатай сонгох бөгөөд зөвхөн Их Хурлаар чөлөөлнө.
5. Аудит, Хяналт шалгалтын хорооны дарга, дэд дарга нь хараат бус байна. Сонгогдсон 4 жилийн хугацаанд гэр бүлийн аль нэг гишүүд нь (эхнэр/нөхөр, хүүхэд, дагавар хүүхэд, эцэг эх, эгч/ах дүүс, хамтран амьдрагч, хадам аав/ээж, хамтран амьдрагчийн эгч/ах дүүс, хүүхдүүд):
 - а. Холбоо, Лиг, Гишүүн, Клуб (хамааралтай компани, байгууллага) –тэй сарын 200 ам.доллар ба түүнээс дээш хэмжээний шууд эсвэл шууд бус аргаар мөнгөн төлбөрийн албан тушаал эрхлэх эсвэл материаллаг гэрээ байгуулсан тохиолдолд;
 - б. Холбооноос гадуурх хуулийн зөвлөхөөр ажилласан эсвэл Холбооны аудиторoor ажилласан (Холбоог аудит хийж байсан) тохиолдолд;
 - с. Холбооны болон/эсвэл аливаа гишүүн байгууллага, тивийн холбоо, Лиг, эсвэл клубтэй жилийн 200 ам. доллар-аас багагүй хэмжээний мөнгөн дүн бүхий ажил сайн дураар эсвэл төлбөрт байдлаар ажилласан төрийн бус байгууллага байвал хараат гэж үзнэ.
6. Тус хорооны дарга, орлогч дарга болон гишүүн нь өөрийн бүрэн эрхийн хугацаанд албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд Гүйцэтгэх Хороо дараагийн Их Хурал болтол уг албан тушаалд ажиллах хүнийг нөхөн томилно.

44-р зүйл. Тэмцээн зохион байгуулах хороо

1. Тус хороо нь Холбооны тэмцээнүүдийг энэхүү дүрмийн заалтууд болон Холбооны тэмцээнд хамаарах журмуудад нийцүүлэн зохион байгуулах үүрэгтэй.
2. Тус хороо нь дарга, орлогч дарга болон 2 гишүүнээс бүрдэнэ.

45-р зүйл. Техникийн ба Хөгжлийн хороо

1. Тус хороо нь хөлбөмбөгийн бэлтгэл, сургалт ба техникийн хөгжлийн үндсэн асуудлуудад дүн шинжилгээ хийнэ. Тус хороо нь дарга, орлогч дарга болон 2 гишүүнээс бүрдэнэ.

46-р зүйл. Шүүгчдийн хороо

1. Тус хороо нь Тоглолтын Дүрмийг хэрэгжүүлэх үүрэгтэй. Түүнчлэн тус хороо нь Холбооноос зохион байгуулагдаж байгаа аливаа тоглолтын шүүгчийг томилох, Холбооны захиргаатай хамтран шүүгчийн асуудлыг зохион байгуулж, шүүгчийн боловсрол, сургалтад хяналт тавих үүрэгтэй. Тус Хороо нь дарга, орлогч дарга болон 2 гишүүнээс бүрдэнэ.
-

47-р зүйл. Эмэгтэйчүүдийн хөлбөмбөгийн хороо

1. Тус хороо нь эмэгтэйчүүдийн хөлбөмбөгийн тэмцээнийг зохион байгуулж эмэгтэйчүүдийн хөлбөмбөгтэй холбогдох бүхий л асуудлыг хариуцна. Тус хороо нь дарга, орлогч дарга болон 2 гишүүнээс бүрдэнэ.
-

48-р зүйл. Хүүхэд залуучуудын хөлбөмбөгийн хороо

1. Тус хороо нь хүүхдийн хөлбөмбөгийн тэмцээнийг зохион байгуулж хүүхдийн хөлбөмбөгтэй холбогдох бүхий л асуудлыг хариуцна. Тус хороо нь дарга, орлогч дарга болон 2 гишүүнээс бүрдэнэ.
-

49-р зүйл. Футзал ба элсний хөлбөмбөгийн хороо

1. Тус хороо нь футзалын ба элсний тэмцээнийг зохион байгуулах ба футзалын ба элсний хөлбөмбөгтэй холбогдох бүхий л асуудлыг хариуцан ажиллана. Тус хороо нь дарга, орлогч дарга болон 2 гишүүнээс бүрдэнэ.
-

50-р зүйл. Тоглогчийн эрх зүйн байдлын хороо

1. ОУХБХ-ноос гаргасан Тамирчдын эрх зүйн байдал ба шилжилт хөдөлгөөний журамд нийцүүлж Тоглогчдын шилжилт хөдөлгөөний талаар өөрийн журам боловсруулж түүний хэрэгжилтэнд хяналт тавьж, Холбооны тэмцээнд оролцож байгаа тоглогчдын эрх зүйн байдлыг тодорхойлно. Тус Хорооны хууль эрх зүйн мэдлийн хэмжээнд заасан тусгай журмыг Зөвлөлөөс гаргаж болно. Хороо нь дарга, дэд дарга болон 2 гишүүнтэй байна.
 2. Холбоо, түүний гишүүд, тоглогчид, албаны хүмүүс, тоглолт болон тоглогчийн агенттай хамаарах тоглогчийн эрх зүйн байдалтай холбогдох аливаа маргааныг энэхүү Дүрэмд заасны дагуу Арбитрын шүүхээр шийдвэрлүүлнэ.
 3. Дарга, дэд дарга ба 2 гишүүдээс бүрдэнэ.
-

51-р зүйл. Түр хороо

1. Шаардлагатай тохиолдолд Зөвлөл тусгай үүрэг гүйцэтгэх Түр хороодыг тодорхой хугацаагаар байгуулж болно. Зөвлөлдөх зөвлөл, Түр хороодын дарга, дэд дарга болон гишүүдийг томилно. Эдгээр Хороодын чиг үүргийг Зөвлөлөөс гаргах тусгай журам, заавраар тодорхойлно. Түр Хороо ажлаа Зөвлөлд шууд тайлагнана.

Е. БУСАД БАЙГУУЛЛАГУУД

52-р зүйл. Клуб лицензжүүлэх байгууллага

1. Тус байгууллага клуб лицензжүүлэх асуудлыг хариуцаж, ажлаа Холбооноос гаргасан Клуб Лицензжүүлэх Журамд нийцүүлнэ.
-

53-р зүйл. Сонгуулийн хороо

1. Тус Хороо нь сонгуулийг Холбооны Сонгуулийн дүрмийн дагуу зохион байгуулж удирдана.

Ё. ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН ГАЗАР

54-р зүйл. Ерөнхий нарийн бичгийн даргын газар

1. Ерөнхий нарийн бичгийн даргын газар нь албан ажлыг Ерөнхий нарийн бичгийн даргын удирдлага дор гүйцэтгэнэ. Ерөнхий нарийн бичгийн даргын газрын албан хаагчид Холбооны дотоод ажлын журамд захирагдаж ажиллана.
-

55-р зүйл. Ерөнхий нарийн бичгийн дарга

1. Ерөнхий нарийн бичгийн дарга нь Ерөнхий нарийн бичгийн даргын газрыг даргална.
2. Ерөнхий нарийн бичгийн даргыг хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр томилох бөгөөд тэрээр зохих мэргэжлийн шаардлагыг хангасан байна.
3. Ерөнхий нарийн бичгийн дарга нь Холбооны дүрэм болон хөдөлмөрийн гэрээнд заасан эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.
4. Ерөнхий нарийн бичгийн дарга нь дараах эрх, үүрэгтэй. Үүнд:
 - 1.1. Их хурал болон Зөвлөлийн гарсан шийдвэрийг Ерөнхийлөгчийн чиглэлийн дагуу хэрэгжүүлэх;
 - 1.2. Их Хурал, Зөвлөл, Шуурхай зөвлөл, Байнгын хороо, Түр хорооны хуралд оролцох;
 - 1.3. Их Хурал, Зөвлөл болон бусад байгууллагуудын хурлыг зохион байгуулах;

- 1.4. Их хурал, Зөвлөл, Шуурхай зөвлөл, Байнгын хороо болон Түр хорооны хурлын тэмдэглэлийг хариуцах;
 - 1.5. Холбооны нягтлан бодох бүртгэлийг зөв хөтлөх;
 - 1.6. Холбооны захидал харилцааг хариуцах;
 - 1.7. Холбооны гишүүд, хороод, ОУХБХ, АХБХ-той харилцах харилцааг хариуцах;
 - 1.8. Ерөнхий нарийн бичгийн даргын газрын бүтэц, зохион байгуулалтыг хариуцах;
 - 1.9. Ерөнхий нарийн бичгийн дарга газрын албан хаагчдыг томилох, чөлөөлөх;
 - 1.10. Удирдах албан тушаалд томилох хүнийг Ерөнхийлөгчид санал болгох;
 - 1.11. Өөрөөр заагаагүй бусад тохиолдолд хороодоос гарсан шийдвэрийг баталгаажуулж гарын үсэг зурах.
5. Ерөнхий нарийн бичгийн дарга нь Их хуралд төлөөлөгчөөр оролцохгүй бөгөөд Холбооны аль нэг байгууллагад гишүүн байж үл болно.

Ж. ЭРХ ЗҮЙН БАЙГУУЛЛАГУУД

56-р зүйл. Эрх зүйн байгууллагууд

1. Холбооны Эрх зүйн бүтцэд дараах хороодыг ойлгоно. Үүнд:
 - а. Сахилгын хороо
 - б. Ёс зүйн хороо
 - в. Маргаан таслах хороо
2. Тус хороо бүр нь дарга, дэд дарга, гишүүд гэсэн таван гишүүдээс бүрдэнэ.
3. Тус хороодын дарга, дэд даргыг гишүүд нь дотроосоо сонгоно.
4. Тус байгууллагууд нь зорилгоо бүрэн биелүүлэхэд шаардагдах мэдлэг чадвар, мэргэшсэн туршлагатай гишүүдээр багаа бүрдүүлнэ. Тус байгууллагуудын дарга нь хуулийг хэрэгжүүлэхэд мэргэшсэн чадвартай байна. Хороодын гишүүд 4 жилээр сонгогдоно. Мөн улиран сонгогдож болно. Хорооны гишүүдийг үүрэгт ажлаас нь хэзээ ч чөлөөлж болох боловч гагцхүү Их Хурлаар чөлөөлөх асуудлыг бүрэн шийдвэрлэнэ.
5. Хороодын дарга, гишүүдийг Зөвлөлийн санал болгосноор Их хурлаас сонгоно.
6. Хороодын дарга, гишүүд нь Зөвлөл, Байнгын хороо Холбооны бүтцийн байгууллагын гишүүн байхыг хориглоно.
7. Эрх зүйн байгууллагын дарга, дэд даргад Аудит, хяналт шалгалтын хорооны дарга, дэд даргад тавигдсан шаардлагын дагуу ижил шаардлага тавина.
8. Хороодын дарга, орлогч дарга эсвэл гишүүн нь бүрэн эрхийнхээ хугацаанд үүрэгт ажлаа бүр мөсөн гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд Зөвлөл нь орны хүнийг ээлжит Их Хурал хүртэлх хугацаанд томилно.
9. Хорооны хариуцлага болон чиг үүргийг Холбооны Сахилгын журам болон Холбооны Ёс зүйн журмаар зохицуулна.

57-р зүйл. Сахилгын хороо

1. Тус хорооны үйл ажиллагааг Холбооны Сахилгын дүрмээр зохицуулна. Хорооны гурван гишүүн оролцсон тохиолдолд хурлаас шийдвэр гарна. Зарим тохиолдолд хорооны дарга нь дангаараа шийдвэр гаргаж болно.
2. Тус хороо нь Холбооны ба Сахилгын дүрэмд заасан шийтгэлийг холбооны гишүүд, албаны хүн, клуб, дундын зуучид ногдуулж болно.
3. Гишүүнээс түдгэлзүүлэх ба хасах зэрэг шийтгэлүүд нь зөвхөн Их хурал ба Зөвлөлийн эрх хэмжээний асуудал мөн.
4. ОУХБХ-ны Сахилгын Хорооны дүрмийн зарчмын дагуух Холбооны Сахилгын дүрмийг Зөвлөлөөс гаргана.

58-р зүйл. Ёс зүйн хороо

1. Тус хорооны үйл ажиллагааг Холбооны ёс зүйн дүрмээр зохицуулна. Хорооны гурваас доошгүй гишүүн оролцсон тохиолдолд хурлаас шийдвэр гаргана. Зарим тохиолдолд Хорооны дарга нь дангаараа шийдвэр гаргаж болно.
2. Тус Хороо нь Холбооны Ёс зүйн дүрэмд заасан шийтгэлийг Холбооны гишүүд, албаны хүн, тоглогч, клуб, тоглолт болон тоглогчдын дундын зууч ногдуулж болно.
3. ОУХБХ-ны Ёс Зүйн хорооны дүрмийн зарчмын дагуух Холбооны Ёс зүйн дүрмийг Зөвлөлөөс гаргана.

59-р зүйл. Маргаан таслах хороо

1. Тус хорооны үйл ажиллагааг Холбооны Сахилгын ба Ёс зүйн дүрмээр зохицуулна. Хорооны гурваас доошгүй гишүүн оролцсон тохиолдолд хурлаас шийдвэр гаргана. Зарим тохиолдолд Хорооны дарга нь дангаараа шийдвэр гаргаж болно.
2. Тус Хороо нь Холбооны холбогдох журамд өөрөөр заагаагүй бол Сахилгын ба Ёс зүйн хорооны шийдвэрийн талаар гаргасан гомдлыг хянаж шийдвэрлэнэ.
3. Энэхүү дүрэмд зааснаар Маргаан таслах хорооноос гаргасан шийдвэрийг Холбооны Үндэсний Арбитрын шүүх аль эсвэл Швейцарь улсын Лозанна хотод байршилтай Спортын Арбитрын шүүхээр дахин хянуулж болно.

60-р зүйл. Сахилгын арга хэмжээнүүд

Сахилгын дараах шийтгэлүүд байна. Үүнд:

1. Хувь хүн болон хуулийн этгээдэд
 - 1.1. Сануулах;
 - 1.2. Нээлттэй сануулах;
 - 1.3. Торгох;
 - 1.4. Олгосон шагналыг буцаан авах.
2. Хувь хүнд
 - 2.1. Анхааруулах;
 - 2.2. Тоглолтоос хөөх;
 - 2.3. Тоглолт өнжүүлэх;
 - 2.4. Хувцас солих өрөөнд орох ба/эсвэл сэлгээний суудалд суухыг хориглох;
 - 2.5. Цэнгэлдэх хүрээлэнд орохыг хориглох;
 - 2.6. Хөлбөмбөгт хамааралтай аливаа үйл ажиллагаанд оролцохыг хориглох;
3. Хуулийн этгээдэд

- 3.1. Тамирчны шилжилт хөдөлгөөн хийхийг хориглох;
 - 3.2. Тоглолтыг үзэгчгүй явуулах;
 - 3.3. Тоглолтыг гуравдагч этгээдийн талбай дээр явуулах;
 - 3.4. Тодорхой цэнгэлдэх хүрээлэнд тоглохыг хориглох;
 - 3.5. Тоглолтын дүнг хүчингүйд тооцох;
 - 3.6. Тэмцээнээс хөөх, хасах;
 - 3.7. Эрх хасах;
 - 3.8. Оноо хасах;
 - 3.9. Лигийн зэрэглэл бууруулах;
 - 3.10. Тоглолтыг дахин явуулах.
4. Сахилгын арга хэмжээг дараалал үл харгалзан оногдуулна.

61-р зүйл. Үндэсний Арбитр

1. Холбоо, Лиг, лигийн гишүүд, клуб, тэдгээрийн гишүүд, тоглогч, албаны хүмүүс болон бусад холбоодын албаны хүмүүстэй хамааралтай эсвэл тэдгээрийн хоорондох маргааныг ОУХБХ-ны журам, Дүрэм, эсвэл тухайн асуудалд хамааралтай тусгайлсан дүрэмд Шүүхэд хандахыг зөвшөөрснөөс бусад тохиолдолд Шүүхэд хандахыг хориглоно.
2. Холбоо 60.1.-д заасан маргааныг Холбооны хүлээн зөвшөөрсөн Үндэсний Арбитраар эсвэл Швейцарь улсын Лозанна хотод байрладаг Спортын Арбитрын шүүхээр хянуулж болно.

62-р зүйл. Маргааныг шүүн таслах эрх зүй

1. Холбоо нь тухайн маргааныг Холбооны дотоодын боломжит бүхий л сувгуудыг ашигласны дараа 61-р зүйлд заасны дагуу Үндэсний Арбитрт хандана.
2. Холбоон дахь маргааныг таслах асуудал нь Холбооны эрх мэдлийн хүрээнд хамаарна. Бусад орны болон тивийн Хөлбөмбөгийн Холбоотой үүссэн олон улсын чанартай маргааныг ОУХБХ хариуцна.

63-р зүйл. Спортын Арбитрын Шүүх (CAS)

1. 61-р зүйлд заасны дагуу тухайн маргааныг шүүн таслах эрх Үндэсний Арбитрт хамааралгүй тохиолдолд ОУХБХ-ноос эцэслэн гаргасан шийдвэрийг ОУХБХ-ны Дүрмийн холбогдох зүйлд заасны дагуу Швейцарь улсын Лозанна хотод байршилтай Спортын Арбитрын шүүхээр хянуулж болно. Гэхдээ энэ шүүхээр тоглолтын дүрмийн зөрчил болон 4-өөс доош тоглолт эсвэл 3 сараас бага хугацаанд тоглолтоос түдгэлзүүлсэн тухай шийтгэл, мөн зохих журмын дагуу байгуулагдсан дотоод эсвэл тивийн хөндлөнгийн Арбитрын шүүхийн шийдвэрийг авч хэлэлцэхгүй.

2. ОУХБХ-ны байгууллага, Холбооны зөвшөөрөгдсөн дотоодын Үндэсний Арбитр, аль эсвэл Швейцарь улсын Лозанна хотод байршилтай Спортын Арбитрын шүүхээс гаргасан эцсийн шийдвэрийг Холбоо өөрөө болон түүний гишүүд, тоглогчид, албаны хүмүүс, тоглолтын ба тоглогчдын дундын зуучид бүрэн дагаж мөрдүүлэхийг Холбоо хариуцна.

3. САНХҮҮ

64-р зүйл. Санхүүгийн жил

1. Холбооны санхүүгийн тайлант хугацаа нэг жил байх бөгөөд тухайн жилийн нэгдүгээр сарын 1-нээс эхэлж, арван хоёрдугаар сарын 31-ний өдрөөр дуусна.
 2. Санхүүгийн тайлант хугацаанд орлого зарлагыг тэнцвэржүүлэх менежментийг хийнэ. Холбооны цаашдын үйл ажиллагааны баталгаа болгож нөөц хөрөнгөтэй болох чиглэлийг баримтална.
 3. Ерөнхий нарийн бичгийн дарга нь Холбооны санхүүгийн нэгдсэн тайланг тухайн жилийн арван хоёрдугаар сарын 31-ний дотор гаргана.
-

65-р зүйл. Орлого

1. Холбооны орлого дараах эх үүсвэрээс бүрдэнэ:
 - 1.1. Гишүүнчлэлийн татвар;
 - 1.2. Холбооны маркетингийн ашиг;
 - 1.3. Эрх бүхий байгууллагуудаас ногдуулсан торгууль;
 - 1.4. Холбооны зорилтыг биелүүлэхтэй холбоотой татвар хураамж;
 - 1.5. Хандив;
 - 1.6. Хөлбөмбөгийн үйл ажиллагаатай холбоотой олж буй бүхий л орлого.
-

66-р зүйл. Зарлага

1. Холбооны зардал:
 - 1.1. Төсвийн зардал;
 - 1.2. Их Хурал ба Зөвлөлийн эрх хэмжээний хүрээнд батлагдсан бусад зардал;
 - 1.3. Холбооны зорилтыг биелүүлэхтэй холбоотой бусад зардал.
-

67-р зүйл. Хараат бус ба хөндлөнгийн аудит

1. Их хурлаар батлагдсан Хараат бус ба хөндлөнгийн аудит нь санхүүгийн Хорооноос баталсан санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн зарчмын дагуу хянаж, дүгнэлтээ Их Хуралд танилцуулна. Аудитыг 4 жилээр томилж улируулан ажиллуулж болно.

68-р зүйл. Гишүүний татвар

1. Гишүүний татварыг жил бүрийн нэгдүгээр сарын 31-ний дотор төлсөн байна. Шинэ гишүүд тухайн жилийн татварыг, гишүүнээр элссэн Их Хурлаас хойш 30 хоногийн дотор төлнө.
2. Зөвлөлийн зөвлөмжийг үндэслэж, Их Хурал нь гишүүний татварын хэмжээг 4 жилд нэг удаа тогтооно. Гишүүн бүр ижил хэмжээний татвар төлөх ба татвар нь 100,000 төгрөгөөс дээшгүй байна.

69-р зүйл. Санхүүгийн зохицуулалт

1. Холбоо нь гишүүдээс үүссэн өр төлбөрийг барагдуулахад тухайн гишүүний үл хөдлөх хөрөнгийг нь хурааж болно.

70-р зүйл. Хураамж

1. Холбоо нь тоглолтын хураамж төлөхийг гишүүдээс шаардаж болно.

И. ТЭМЦЭЭН БА ТЭМЦЭЭНИЙ БОЛОН БУСАД АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮЕЭР ЭДЛЭХ ЭРХ

71-р зүйл. Тэмцээнүүд

1. Холбоо нь Монгол улсын нутаг дэвсгэрт албан ёсны дараах тэмцээнүүдийг өмчилж, зохион байгуулж зохицуулна:
 - 1.1. Өсвөр ба Идэрчүүдийн 4 насны тэмцээн;
 - 1.2. Залуучуудын УАШТ;
 - 1.3. Футзалын бүх насны тэмцээн;
 - 1.4. Эмэгтэйчүүдийн хөлбөмбөгийн тэмцээн;
 - 1.5. Үндэсний Лиг;
 - 1.6. Холбооны цом;
 - 1.7. Үндэсний цом;
 - 1.8. Сонирхогчдын тэмцээн;
 - 1.9. Ахмадын тэмцээн;
 - 1.10. Бүсийн аварга шалгаруулах тэмцээн.
2. Зөвлөл нь Орон нутгийн хөлбөмбөгийн холбоонд тэмцээн зохион байгуулах эрх олгож болно. Эдгээр тэмцээнүүд нь Холбооноос зохион байгуулж буй тэмцээнүүдтэй давхардаж үл болох бөгөөд Холбооны тэмцээнүүдэд тэргүүн ач холбогдол өгнө.
3. Орон нутгийн хөлбөмбөгийн холбоонд тэмцээн зохион байгуулах эрх олгох талаар Зөвлөлөөс тусгай журам гаргаж болно.

74-р зүйл. Клубийн лиценз

1. Холбоо нь уралдаан, тэмцээнд клубүүд хэрхэн яаж оролцох тогтолцоог тодорхойлсон клуб лицензжүүлэх журмыг Зөвлөлөөс гаргана. Энэ нь ОУХБХ-ны клуб лицензжүүлэх журамд нийцсэн АХБХ-ны гаргасан тогтолцооны зайлшгүй шаардлагыг хангасан байна.
-

75-р зүйл. Тэмцээний эрх

1. Холбоо болон түүний гишүүд өөрийн эрх зүйн мэдлийн хүрээнд зохион явуулж буй тэмцээн болон бусад арга хэмжээтэй холбоотой бүхий л эрхийн анхдагч эзэмшигч мөн. Үүнд тэмцээний агуулга, явуулах цаг хугацаа ба байршилд хязгаар тогтоохгүй. Эзэмших эрх дотор санхүүгийн бүхий л төрлийн эрх, дуу дүрс ба радио бичлэг, хувилах ба дамжуулах эрх, мультимедиа эрх, маркетинг ба сурталчилгааны эрх, зохиогчийн эрхийг хамгаалах хуулийн хүрээнд багтсан тухайлбал эмблем гэх зэрэг эрхүүд багтана.
 2. Дээрх эрхийг ямар хэмжээнд, хэрхэн яаж эдлэх асуудлыг Зөвлөл шийдвэрлэх бөгөөд уг асуудлаар тусгай журам гаргана.
-

76-р зүйл. Эрх олгох

1. Холбоо болон түүний гишүүд өөрийн эрх зүйн мэдлийн хүрээнд зохион явуулж буй тэмцээн болон бусад арга хэмжээтэй холбоотой дүрс, дуу авиа, бусад мэдээллийг түгээн дэлгэрүүлэх эрхийг олгох онцгой эрх эдэлнэ. Тэмцээний агуулга, цаг хугацаа, газар, техникийн болон хууль зүйн талаас хязгаар тогтоохгүй.
-

Й. ОЛОН УЛСЫН ТОГЛОЛТ БА ТЭМЦЭЭН

77-р зүйл. Олон улсын тоглолт ба тэмцээн

1. Шигшээ баг, лиг болон клубын багийн олон улсын тоглолт ба тэмцээнийг зохион явуулах эрх мэдлийг зөвхөн ОУХБХ, Тивийн Холбоод болон ОУХБХ-ны гишүүн Холбоод эдэлнэ. Дэлхийн Хөлбөмбөгийн Холбооны олон улсын тоглолтыг зохицуулах журамд зааснаар ОУХБХ, Тивийн Холбоод болон ОУХБХ-ны гишүүн Холбооны урьдчилсан зөвшөөрөлгүйгээр ямарч тэмцээн болон тоглолт явагдахгүй.
 2. Холбоо нь ОУХБХ-ноос гаргасан олон улсын тэмцээнүүдийн календарьчилсан төлөвлөгөөг дагаж мөрдөнө.
-

78-р зүйл. Харилцаа холбоо

1. Холбоо, түүний гишүүд, тоглогчид, албаны хүмүүс, тоглолтын болон тоглогчдын агентууд нь ОУХБХ-ны зөвшөөрөлгүйгээр ОУХБХ-ны гишүүн бус Холбоод, эсвэл Тивийн Холбооны албан бус гишүүн Холбоотой тоглолт хийх, эсвэл спортын арга хэмжээнд оролцож үл болно.

79-р зүйл. Зөвшөөрөл

1. Холбоонд харьяалагдах клуб, лиг ба багууд нь зөвхөн Холбоо, ОУХБХ-ны гишүүн бусад байгууллага, харьяалагдах тивийн Холбоо, ОУХБХ-ны зөвшөөрлөөр ОУХБХ-ны гишүүн бусад байгууллагатай харилцаатай байж болно.
2. Холбоонд харьяалагдах клуб, лиг ба багууд нь ОУХБХ-ны олон улсын тоглолтыг зохицуулах журамд зааснаар Холбоо, ОУХБХ-ны бусад гишүүн байгууллага, ОУХБХ болон харьяалагдах тивийн Холбооны зөвшөөрөлгүйгээр ОУХБХ-ны бусад гишүүн байгууллагын нутаг дэвсгэрт зохион явуулж буй тэмцээнд оролцож үл болно.

К. ТӨГСГӨЛ

80-р зүйл. Урьдчилан тооцоолох боломжгүй болон давагдашгүй хүчин зүйлс

1. Энэхүү дүрэмд тусгагдаагүй бусад өөр асуудлаар болон давагдашгүй нөхцөл байдал бий болсон тохиолдолд ОУХБХ ба АХБХ-ын холбогдох журмын дагуу эцсийн бодит шийдвэр гаргах эрхийг Зөвлөл эдэлнэ.

81-р зүйл. Татан буулгах

1. Холбоог татан буулгах шийдвэр гаргахад тусгайлан Их Хурлыг хуралдуулж төлөөлөгчдийн гуравны хоёрын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.
2. Холбоог татан буулгах нөхцөлд түүний хөрөнгийг хүлээн авах этгээдийг Холбооны Их Хуралд оролцсон төлөөлөгчдийн гуравны хоёрын саналаар сонгож шийдвэрлэнэ.

82-р зүйл. Дүрэм хүчин төгөлдөр болох нь

1. Энэхүү Дүрэм нь 2018 оны 3-р сарын 23-ны өдөр Улаанбаатар хотноо хуралдсан Холбооны ээлжит Их Хурлаар батлагдсан бөгөөд мөн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

83-р зүйл. Төгсгөлийн зүйл

1. Холбооны одоогийн байгууллагуудын бүрэн эрхийн хугацааг тухайн бүрэн эрхийн хугацаа дуусгавар болох хүртэл хүчин төгөлдөр хэвээр гэж үзнэ.
2. Шүүгчийн зөвлөл, Дасгалжуулагчийн зөвлөл, эмэгтэйчүүдийн зөвлөл, ахмадын зөвлөл, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зөвлөл байгуулагдаагүй тохиолдолд байгуулагдах хүртэл 22.1-д заасны дагуу санал өгөх эрхгүй гэж үзнэ.
3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зөвлөл байгуулагдаагүй тохиолдолд 33.1-д заасан Зөвлөлийн 1 суудлыг хоосонд тооцно.